Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2012 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн
29 дүгээр тушаалын 3-р хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
# ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

## БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛД ХЯНАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ДҮГНЭЛТ

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл.

1. Барилга байгууламжийн байршил: Хэнтий аймаг, Мөрөн сум,
2. Зургийн шифр, зураг төслийн байгууллага: BS00102/-01L-1, "Баясал төгс" ХХК захирал Г.Жавхлантуг
3. Барилга байгууламжийн зориулалт: Соёлын төвийн барилгын цахилгаан хангамжийн 35 кв-ын ЦДАШ, 35/0,4 кв-ын 250 ква чадалтай дэд станц
4. Барилга байгууламжийн багтаамж, куб.м:
5. Барилгын давхар, приметр:
6. Галд тэсвэршилтийн зэрэг: төлөвлөсөн: II
7. Үйлдвэрлэлийн ангилал :
8. Барилгын үүргийн галын аюулын анги: IV
9. Зургийн иж бүрдэл: 1 хэсэг хуудас
10. Галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

10.1. Гал унтраах автомат тоног төхөөрөмж: үгүй
10.2. Галын дохиололын зураг: үгүй
Гал унтраах дотор усан хангамж: үгүй

*Хоёр: хяналт шалгалт хийсэн тухай тэмдэглэл.*

| № | Хянаж шалгасан чиглэл | | Илэрсэн зөрчил | БНбД, стандартын зөрчигдсөн заалт | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ерөнхий төлөвлөгөө, галын аюулгүйн зай хэмжээ | Барилга хоорондын зай | | | + |
| | | Галын автомашины зам | | | |
| | | Үер усны хамгаалалт | | | + |
| 2 | Архитектур төлөвлөлт, байгуулалт, хийц бүтээцийн шийдэл | Барилгын материал | | | + |
| | | Гадна шат | | | |
| | | Дотор шат, шатны хонгил, цахилгаан шат | | | |
| | | Галаас хамгаалах хаалт, хаалга | | | |
| | | Галаас тусгаарлах зааг, өрөө тасалгаа | | | |
| | | Дээвэр | | | |
| | | Газар доорхи давхарын зориулалт | | | |
| | | Авралтын зам гарч | | | + |
| 3 | Галаас хамгаалах техник, тоног төхөөрөмж | Гал унтраах автомат тоног төхөөрөмж | | | |
| | | Галын дохиололын | | | |

БАТЛАВ.
БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ТАВИНБЭХ

БАГАНУУР ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК 2717248350 2008904

## ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2019 оны 07-р сарын 29-ний өдөр № ХЭ 19/33 Багануур дүүрэг

| | |
|---|---|
| 1. **Техникийн нөхцөл хүссэн хуулийн этгээд:** | ХЭНТИЙ АЙМАГ МӨРӨН СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР |
| 2. **Хэрэглэгчийн хаяг:** | Хэнтий аймаг, Мөрөн сум, 4-р баг<br>Утас: 96643167 |
| 3. **Хэрэглэгчийн байршил, зэрэглэл:** | Хэнтий аймаг, Мөрөн сум, 4-р баг, Засаг даргын тамгын газрын зүүн талд<br>3-р зэрэглэл |
| 4. **Ажил үйлчилгээний зориулалт:** | Соёлын төвийн барилгын цахилгаан хангамж |
| 5. **Техникийн нөхцөл олгох үндэслэл:** | 2019 оны 06-р сарын 25-ны өдрийн №01/179 тоот албан бичиг |
| 6. **Хэрэглээний нийт чадал:** | 150 кВт |
| 7. **Холбогдох цэг:** | **7.1** 35 кВ-ын Мөрөн ЦДАШ-ын тулгуур №7-с 30 м-н зайд "П" хэлбэрийн портал угсарч 35 кВ-н хуурай салгуур, микропроцессорын хамгаалалт бүхий реклоузер таслуур суурилуулна.<br><br>**7.2** Шинээр угсарсан "П" хэлбэрийн портал дээрх 35 кВ-ын реклоузер таслуураар дамжуулж 70 мм$^2$-аас багагүй хөндлөн огтлолтой АС маркийн дамжуулагчтай, төмөр бетон тулгууртай 35 кВ-ын ЦДАШ угсарч төгсгөлд нь **250 кВА** чадалтай 35/0.4 кВ-ын хүчний трансформатор бүхий АТП маягийн дэд өртөөг барина.<br><br>**7.3** 35/0.4 кВ-ын дэд өртөөний 35 кВ талд 35 кВ-ын цэнэг шавхагч, хуурай салгуур, гал хамгаалагч, 250 кВА чадалтай хүчний трансформатор, 0.4 кВ талд нь 0.4 кВ-ын иж бүрэн хуваарилах хайрцаг суурилуулна. |

| | |
|---|---|
| **8. Тоолуур хэмжих хэрэгсэл:** | **8.1** 35/0.4 кВ-ын дэд өртөөний 0.4 кВ талд Монгол улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвөөс загварын туршилтанд орж, ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан IEC 61861-1 стандартын шаардлага хангасан 400/5 коеффициенттэй гүйдлийн трансформатор, RS-485, PLC болон GSM /2G, 3G/-р гадны төхөөрөмжтэй холбогдох боломжтой IEC 62056 стандартын шаардлага хангасан 0.5S нарийвчлалтай, санах ойтой, олон үйлдэлтэй 5 А-н ухаалаг тоолуур суурилуулна. |
| **9. Тусгай заалтууд:** | **9.1** Шинээр угсрах 35 кВ-ын ЦДАШ, 35/0.4 кВ-ын дэд өртөөний ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн, техникийн нөхцөл олгогч болон ашиглалт стандартчиллын инженерээр хянуулж, магадлан хяналтаар баталгаажуулна.<br><br>**9.2** Шинээр угсрах 35 кВ-ын ЦДАШ-ын трассын зураг, схемийг Хэнтий ЦТСС-ын инженер техникийн ажилчидтай хамтран гаргана.<br><br>**9.3** Шинээр баригдах 35/0.4 кВ-ын дэд өртөөнд "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 1.6.41-н дагуу эсэргүүцэл нь 4 Ом-с ихгүй байхаар газардуулга хийнэ.<br><br>**9.4** Шинээр угсрах 35 кВ-ын ЦДАШ, 35/0.4 кВ-ын дэд өртөө нь бусдын эзэмшлийн газар нутаг, инженерийн байгууламжийг огтлолцож байгаа цэгүүдэд холбогдох эрх бүхий байгууллагаас техникийн зөвшөөрөл авна.<br><br>**9.5** Хэнтий аймгийн газрын албанаас шинээр баригдах 35/0.4 кВ-ын дэд өртөөний байрлал, 35 кВ-ын ЦДАШ-ын трассын дагуу газрын зөвшөөрөл авч баталгаажуулан мэдээллийн санд оруулна.<br><br>**9.6** Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдлийн түвшингийн ±5%-ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй, орчин үеийн шинэ найдвартай тоног төхөөрөмж суурилуулна.<br><br>**9.7** 35 кВ-ын ЦДАШ, 35/0.4 кВ-ын дэд өртөөний барилга угсралтын ажлыг "Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл"-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.<br><br>**9.8** Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, |

шаардлагатай хэмжилт туршилтыг БЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтий ЦТСС-аар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

**9.9** 110/35/6 кВ-ын Өндөрхаан дэд станцын 35 кВ-ын Мөрөн гаргалгааны реле хамгаалалтын тавилын тооцоо, зохицуулалтыг БЗӨБЦТС ТӨХК-р хийлгэж, ДҮТ ХХК-р хянуулна.

**9.10** Хэрэглэгч нь 110/35/6 кВ-ын Өндөрхаан дэд станцын 35 кВ-ын Мөрөн гаргалгааны гүйдлийн трансформаторын ачааллыг тооцож, шаардлагатай тохиолдолд гүйдлийн трансформаторыг солино.

**9.11** Шинээр угсарсан "П" хэлбэрийн портал, 35/0.4 кВ-ын дэд өртөөнд "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн дагуу хашаа хийнэ.

**9.12** Тухайн хэрэглэгч нь түгээх сүлжээнд холбогдсон нөхцөлд цахилгааны хэрэглээ, цахилгаан тоног төхөөрөмжийн ажиллагаа нь түгээх сүлжээний үндсэн параметр болох хүчдэл, давтамжийн утганд нөлөөлж нэгдсэн сүлжээний дүрэмд заасан зөвшөөрөгдөх утгаас хэлбэлзэх, огцом буурах, өсөх, тоноглолын ачааллагдах хэмжээ зөвшөөрөгдөх хязгаараас давах мөн байгалийн онц ноцтой хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн түгээх сүлжээний үйл ажиллагаа доголдох, саатах нөхцөл байдал үүссэн тохиолдолд түгээх сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангахын тулд хугацаа харгалзахгүй цахилгаан эрчим хүчээр хязгаарлах, түдгэлзүүлэх нөхцлөөр холбогдоно.

**9.13** Техникийн нөхцөл, горимын тооцоонд заагдсан чадал, хэрэглээг нэмэгдүүлэхийг хориглоно.

**9.14** Төвийн эрчим хүчний системийн төлөв байдалтай уялдуулж БЗӨБЦТС ТӨХК-иас батласан горимын дагуу ажиллана.

**9.15** Шаардлагатай тохиолдолд хязгаарлалтын горимд ажиллана.

| | |
|---|---|
| 10. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх: | **10.1** Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23 дугаар заалт, БЗӨБЦТС ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтанд хүлээн авах журам"-ын дагуу холбогдоно. |

**10.2** Цахилгаан тоноглол болон агаарын шугам, кабель шугамын ашиглалт үйлчилгээний талаар БЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтий ЦТССалбарын шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.

**10.3** Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.4, 30.1.7, 30.1.8 дугаар заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

**10.4** Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бус барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

**10.5** Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.3 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

**10.6** Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

**10.7** Хэрэглэгч нь "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 4.2.72, 4.2.73, 4.2.74-р заалтуудыг баримталж угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

**10.8** Эрчим хүчний сайдын 2013 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 03 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам"-ын 5 дахь хэсэгт заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.

5.2 Техникийн нөхцлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:

5.2.1 Техникийн нөхцөл авахын тулд техникийн хэрэглээний өгөгдлүүдээ зориуд буруу тодорхойлсон.

5.2.2 Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон.

5.2.3 Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд.

5.2.4 Хугацаа дууссан техникийн нөхцлөөр зураг

төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно.
5.2.5 Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтийг ажлын хэсэгт гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцлийг хүчингүйд тооцно.

**10.9 Техникийн нөхцөлд тусгагдсан заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд техникийн нөхцлийг хүчингүйд тооцно.**

**10.10 Техникийн нөхцлийн дагуу барилга угсралтын ажлыг хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэн түгээх сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийж гүйцэтгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.**

Хянасан: ТҮАХТэргүүн дэд захирал, Ерөнхий инженер — Г.Шүрэнчулуун

ТҮАХБХ-ийн дарга — Д.Мөнхтулга

Боловсруулсан: ТНОЗ-ийн инженер — А.Бямбажаргал